



БАЯНДЭЛГЭР СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Баяндэлгэр сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Баяндэлгэр сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баяндэлгэр сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 32043.2 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 33440.7 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 1397.5 мянган төгрөгөөр буюу 104.4 хувиар давуулан биелүүлсэн байна.
- ОНХСангаас худалдан авсан малын үүлдэр сайжруулах зорилготой малыг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Орон нутгийн төсвөөс 134173.8 мянган төгрөгийг ОНХСанд ИТХурлын тогтоолоор батлан 109873.5 мянган төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна
- Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэн Хөрөнгө оруулалтын 7 арга хэмжээнд зарцуулан, 24300.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг дутуу ирж дараа жилийн шилжих зардал болон үлдсэн байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
УАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа*

*илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014 оны 3-р сарын 25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.24

Танилцуулга

Баяндэлгэр сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баяндэлгэр сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Баяндэлгэр сумын Засаг даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Баяндэлгэр сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Баяндэлгэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 20-ний өдрийн 02-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 32?43.2 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 33440.7 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 1397.5 мянган төгрөгөөр буюу 104.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 62185.9 мянган төгрөг, гүйцэтгэлээр 65167.4 мянган төгрөг буюу биелэлт 104.8 хувьтай биелж, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 8420 мянган төгрөг, гүйцэтгэлээр 85758.4 мянган төгрөг биелэлт 1018 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 2780.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 31048.7 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 552722.8 мянган төгрөг, нийт 583771.5 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 185332 мянган төгрөг, ИТХУралд 28131.2 мянган төгрөг, Багт 18886.1 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс Халамжид 66797.6 мянган төгрөг буюу нийт НЕҮ-д 299146.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 284624.6 мянган төгрөгийг Тусгай шилжүүлгийн байгууллагуудыг санхүүжүүлсэн байна. Орон нутаг буюу дээд шатны байгууллагаас санхүүжсэн дүнг авч үзвэл

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 258271.7 мянган төгрөг, Цэцэрлэгт 122932.9 мянган төгрөг, Эмнэлэгт 165725.5 мянган төгрөг, Соёлын төвд 58519.1 мянган төгрөг нийт 605449.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 9831.5 мянган төгрөгийг, НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 3023 мянган төгрөгийг болон оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 12854.5 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 66797.6 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 39053 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 16794 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 1050 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 6729.2 мянган төгрөг зарцуулсан байна.бусад хөнгөлөлт тэтгэмжинд 3174.4 мянган төгрөгийн зарцуулан үлдэгдэлгүй гарсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 31437.0 мянган төгрөг, Сургууль 1460.0 мянган төгрөг, ЭМТөв 760.0 мянган төгрөг, Соёлын төвд 4178.5 нийт 9542.2 мянган төгрөгийн орлого, 8914.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 3806.2 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 681,2 мянган төгрөг, Соёлын төв 944.0 мянган төгрөг, ЭМТөв 349.0 мянган төгрөг, Сургууль 150.0 мянган төгрөг, нийт 2124.2 мянган төгрөг орж зарцуулагдсан байна

Сум Хөгжлийн Санд 50000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй Сум хөгжүүлэх дансан шууд хийгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 10446.6 мянган төгрөг, ИТХурал 652.2 мянган төгрөг, Баг 121.1 мянган төгрөг нийт 10719.9 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 68852.87 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 2780.7 мянган төгрөг, эм эргэлтийн сан 3191.8 мянган төгрөг, нийт 83045.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 94142.7 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 7627.1 мянган төгрөг, эм эргэлтийн сан 873.7 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 3628.9 нийт 106272.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгааатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд НЕҮ тусгай сангууд 94160.6 мянган төгрөг Тусгай зориулалтын шилжүүлэг 856.4 мянган төгрөгийн авлага нийт 95650.8, оны эцэст 147260.8 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 51610.0 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 122751.0 мянган төгрөг, мал хамгаалах санд хөтөлбөрт арга хэмжээний авлага 21615.6 мянган төгрөгийн буюу 98.0 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага болон мал хамгаалах сангийн авлага эзэлж байна. Өглөгө оны эхэнд 1460.7 мянган төгрөг, оны эцэст 1408.0 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст өглөг өөрчлөлт ороогүй байна.

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 58400.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 114252.3 мянган төгрөгийн бараа материал

нэмэгдэж, 104378.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 68274.3 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 2805571.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 104676.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 12665.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 2897582.7 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 1835274.3 мянган төгрөг үлдэх өртөг 1062308.4 мянган төгрөг байна

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 7 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Тус сангийн харилцах данс нь оны эхний үлдэгдэл 1704.8 мянган төгрөг байснаас тайлант оны турш 8016.9 мянган төгрөгний орлого санхүүжилт төвлөрч бүрдэл болсон 25 ширхэг төлбөрийн даалгавраар 3876.2 төгрөг зарцуулж дансанд 5845.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлсэн байна. Үүнд:

Байгальд нэвтэрсний хураамж 416.6 мянган төгрөг, 2013 оны аймгийн төсвөөс 9000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирүүлснээс 7600.0 мянган төгрөгний санхүүжилт хийгдэж 1400.0 мянган төгрөг орон нутгийн орлогийн дансанд үлдэгдлээр байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн зардалд 3876.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн 140552400 тоот дансыг Төрийн санд нээж тайланд онд 109873.5 мянган төгрөгийн санхүүжилт, ойн хандив 63971.8 мянган төгрөг орлого, 171326.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 102354.9 мянган төгрөг, ойн арга хэмжээнд 68971.8 мянган төгрөг тус тус зарцуулагдсан жилийн эцэст харилцах дансанд 2618.6 мянган төгрөгний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХурлын 05-р хуралдаанаар 2012 оны 12-р сарын 20-ны өдрийн 03 тоот тогтоолоор 11 төсөл хөтөлбөрт 159000.0 сая төгрөгөөр баталсан. Аймгийн хэмжээнд олгох санхүүжилт буурсантай холбогдуулан сумын ИТХурлын 2013 оны 1-р сарын 18-ны өдрийн 10 тоот тогтоолоор 7 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 134173.8 сая төгрөгийг баталсан байна.

Тайлант онд ОНХСангийн санхүүжилтэнд 109873.5 мянган төгрөгийг олгосон СТСХэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 109873.5 мянган төгрөг буюу зөрүүгүй байна. Тайлант оны санхүүжилтээс 107254.9 мянган төгрөгийн ажил хийгдсэн 24300.3 мянган төгрөгийн ажил хийгдээгүй байна. Хөрөнгө оруулалтын хийгдсэн ажлыг тодруулахад:

Нийтийн бохирын цооног бие засах газарыг Д.Адъяа ахлагчтай Хөндлөн булаг иргэдийн бүлэг 18000.0 мянган төгрөг, Наадмын тайлбай их засварын ажилыг Ч.Пүрэвбазар ахлагчтай иргэний бүлэг 10000.0 мянган төгрөг, Автобусны буудал барихад 1985 оны төгсөгчид 2000.0 мянган төгрөг, Малын үүлдэр угсаа сайжруулахад 30 эцэг мал Дэлгэр ажнай ХХК 10000.0 мянган төгрөг, Хадлангийн өвс хаман боогч Д.Гүндэгмаа

9000.0 мянган төгрөг, Халуун ус ахуйн үйлчилгээний цогцолбор Зөв лхам ХХК 69800.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээс 51354.9 мянган төгрөгний санхүүжилт олгогдсон.

Мал хамгаалах сангийн талаар:

Тайлант хугацаанд мал хамгаалах сангийн харилцахын эхний үлдэгдэл 4202.4 мянган төгрөг байсан ба тайлант онд 19909.6 мянган төгрөг төвлөрсөн байна. Үүнээс:

Сумын нөөцөнд өвс татхад 2726.3 мянган төгрөг, бусад зардалд 180.0 мянган төгрөг нийт тайлант хугацаанд 2906.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сан нь оны эхэнд 61593.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба санхүүгийн дэмжлэг 50000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн ба зээл, зээлийн хүүний эргэн төлөлтөөс 116318.7 мянган төгрөг нийт 166318.7 мянган төгрөг төвлөрсөн ба 145286.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэнээс 31 хүнд 143187.5 мянган төгрөгийн зээлийг олгосон ба үйл ажиллагааны зардалд 2286.7 мянган төгрөгийг олгосон байна. Эцэсийн үлдэгдэл 82625.5 мянган төгрөг байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Тус сангийн харилцах данс нь оны эхний үлдэгдэл 1250.0 мянган төгрөг байснаас тайлант 450.0 оны турш мянган төгрөгний орлого санхүүжилт төвлөрч сангийн эцэсийн үлдэгдэл 1700.0 мянган төгрөг байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012 оны 11-р сарын 9-ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторовн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын

хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31–нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014-03-24